

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам” (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Ашигт малтмалын тухай хуульд заасан үндэслэлээр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг (цаашид “Тусгай зөвшөөрөл” гэх) олгох сонгон шалгаруулалтыг зохион явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Сонгон шалгаруулалтыг шударга, ил тод, нээлттэй өрсөлдөх тэгш боломжоор хангах, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг баримтлан олон нийтийн хяналтын дор явуулна.
- 1.3. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.2 дахь хэсэгт тусгасан хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогод нийцүүлэн сонгон шалгаруулалтыг зохион явуулна.
- 1.4. Стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагт хамаарсан талбайд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “Төрийн захиргааны төв байгууллага” гэх) нь Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.5. Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгоходо энэхүү журмыг баримтална.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайг ялгах, нийтэд мэдээлэх

- 2.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “Төрийн захиргааны байгууллага” гэх)-ын Кадастрын асуудал хариуцсан нэгж нь Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэгт заасан ажиллагааг явуулна.
- 2.2. Төрийн захиргааны байгууллага нь Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т зааснаар аймаг, Нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 2.3. Засгийн газар нь Төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтын дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтооно.
- 2.4. Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтийг гаргах, түүнийг бүртгэх

- 3.1. Сонгон шалгаруулалтын бэлтгэл хангах.
 - 3.1.1. Төрийн захиргааны байгууллагын Кадастрын асуудал хариуцсан нэгж нь Засгийн газраас тогтоосон талбайгаас Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5, 17.6, 17.7-д заасан шаардлагыг хангасан талбайг тухай бүр ялгаж, талбай тус бүрээр багц мэдээллийг бэлтгэх ажлыг хариуцна.
 - 3.1.2. Төрийн захиргааны байгууллагын Геологийн асуудал хариуцсан нэгж нь сонгон шалгаруулалт явуулах талбай тус бүрийн геологи-ashiгт малтмалын багц мэдээллийг бэлтгэж, Кадастрын асуудал хариуцсан нэгжид шилжүүлнэ. Үүнд:
 - Талбайн геологийн судалгааны товч түүх;

- Талбайн геологийн тогтоц;
 - Талбайн ашигт малтмалын мэдээлэл;
 - Тухайн талбайн хэмжээнд нөөц бүртгэгдсэн бол нөөцийн хөдөлгөөний тухай мэдээлэл (энэ тохиолдолд Төрийн захиргааны байгууллагын уул уурхайн асуудал хариуцсан нэгж мэдээллийг бэлтгэнэ).
- 3.1.3. Журмын 3.1.1-д заасан мэдээллийг Төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу бэлтгэнэ.
- 3.1.4. Төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалт явуулах талбайн багц мэдээллийг тухай бүр Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 3.1.5. Төрийн захиргааны төв байгууллага нь багц мэдээлэлтэй танилцаж, сонгон шалгаруулалт явуулах талбайг эцэслэн сонгож, Төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.2. Сонгон шалгаруулалтын урилга

- 3.2.1. Журмын 3.1.5-д заасан талбайд сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.
- 3.2.2. Сонгон шалгаруулалтын урилгад дараах мэдээллийг тусгасан байна.
- 3.2.2.1. Сонгон шалгаруулалтын талбайн байршил, талбайн нэр;
 - 3.2.2.2. Талбайн солбицол;
 - 3.2.2.3. Талбайн хэмжээ /гектараар/;
 - 3.2.2.4. Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтийг ирүүлэх хаяг, хүлээн авах албан тушаалтан, холбогдох утасны дугаар;
 - 3.2.2.5. Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа;
 - 3.2.2.6. Сонгон шалгаруулалтанд оролцохоор ирүүлсэн саналыг нээх хугацаа, газар;
 - 3.2.2.7. Сонгон шалгаруулалтын босго үнэ;
 - 3.2.2.8. Сонгон шалгаруулалтын үнийн саналыг байршуулах дансны дугаар;
 - 3.2.2.9. Сонгон шалгаруулалтын багц мэдээллийг авах газрын хаяг, үйлчилгээний хураамж, дансны дугаар.
- 3.2.3. Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа нь журмын 3.2.1-т заасны дагуу сонгон шалгаруулалтын урилга үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлэгдсэнээс хойш хуанлийн 30 (гуч) хоногоос доошгүй байна.

3.3. Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлт, түүнд тавигдах шаардлага.

- 3.3.1. Сонгон шалгаруулалтанд оролцогч хуулийн этгээд нь Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан баримт бичгийг энэ журмын 3.3.3, 3.3.4-т заасны дагуу бурдүүлж, нэг хавтсанд битүүмжилж, сонгон шалгаруулалтанд оролцох тухай хүсэлт болон тухайн хуулийн этгээдийг төлөөлөх эрхийг нотолсон баримт бичгийн хамт ирүүлнэ.
- 3.3.2. Техникийн саналд дараах бичиг баримтыг хавсаргасан байна. Үүнд:
- 3.3.2.1. Төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан сонгон шалгаруулалтанд оролцогчийн албан ёсны тодорхойлолт;
 - 3.3.2.2. Тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
 - 3.3.2.3. Монгол Улсад татвар төлөгчөөр бүртгүүлсэн тухай татварын албаны тодорхойлолт;
 - 3.3.2.4. Сонгон шалгаруулалтын босго үнийг Монголбанкинд бүртгэлтэй арилжааны банкинд хугацаатай байршуулсан тухай баталгаа;

- 3.3.2.5. Тухайн талбайд гүйцэтгэх геологи хайгуулын ажлын төрөл, хугацаа, өртөг болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах зардал бүхий төсөл, төсөв хэрэгжүүлэх төлөвлөгөөний санал;
- 3.3.2.6. Геологи, хайгуул, байгаль орчныг хамгаалах болон нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах тоног төхөөрөмжийн жагсаалт (техник, тоног төхөөрөмжийн эзэмшигчийг нотолсон гэрчилгээ, паспорт болон бусад баримт бичгийг нотариатаар гэрчлүүлсэн байна);
- 3.3.2.7. Мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал (боловсон хүчин нь тухайн хуулийн этгээдийн ажилтан болохыг баталсан баримт бичиг болон мэргэжилтэй, мэргэшсэн болохыг баталсан боловсролын үнэмлэх, диплом, гэрчилгээг нотариатаар гэрчлүүлсэн байна);
- 3.3.2.8. Орон нутгийг хөгжүүлэх, хамтран ажиллах төлөвлөгөө (ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт болон орон нутгийн бизнесийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, бэлчээр ашиглах уламжлалыг хадгалан хамгаалах, хөгжүүлэх, усжуулах ажилд дэмжлэг үзүүлэх, түүх, соёлын дурсгалт газрыг хадгалж, хамгаалах талаар тусгасан байна.)
- 3.3.2.9. Төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан талбайн байршил, түүний булангийн цэгүүд бүхий талбайн зураг;
- 3.3.2.10. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5-д заасан үйлчилгээний хөлс төлсөн баримт;
- 3.3.2.11. Тухайн хуулийн этгээдийн дүрэм (хамгийн сүүлийн байдлаар улсын бүртгэлийн байгууллагаар баталгаажуулсан байна);
- 3.3.3. Үнийн саналыг Төрийн захиргааны байгууллагын баталсан маягтын дагуу тоо болон үсгээр зөрүүгүй үйлдэж төслийн үндсэн баримт бичгээс тусд нь эх болон хуулбар хувь тус бүрт битүүмжлэн хийсэн байна.
- 3.3.3.1. Сонгон шалгаруулалтын талбайн босго үнэ 2240 төг/га, хэрэв эрдсийн хуримтлал бүхий талбай бол 4480 төг/га байхаар тус тус тооцох бөгөөд тухайн зарлагдсан талбайн хэмжээнд дүйцэх мөнгөн дүнг “босго үнэ” гэнэ. Босго үнийг сонгон шалгаруулалтанд оролцогч нь журмын 3.3.3.3-д заасны дагуу байршуулсан байна.
- 3.3.3.2. Сонгон шалгаруулалтанд оролцогч нь үнийн саналдаа журмын 3.3.3.1-д заасан босго үнийг оруулж тооцно.
- 3.3.3.3. Сонгон шалгаруулалтын босго үнийг Монголбанкинд бүртгэлтэй арилжааны банкинд хугацаатай байршуулж, баталгаа гаргуулах бөгөөд уг баталгааг сонгон шалгаруулалтын саналын хамт ирүүлнэ. Баталгааны загварыг Төрийн захиргааны байгууллага батална.
- 3.4. Сонгон шалгаруулалтын саналыг Төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу бүрдүүлж, хуудас тус бүрийг дугаарласан байна.
- 3.5. Сонгон шалгаруулалтанд оролцох санал нь “эх хувь” ба “хуулбар хувь” гэсэн 2 (хоёр) хувь байх бөгөөд тус тусад нь битүүмжлэн ирүүлнэ. Эх ба хуулбар хувьд дахь техникийн болон үнийн саналуудыг журмын 3.3.2, 3.3.3-т заасны дагуу бүрдүүлсэн байна.
- 3.6. Сонгон шалгаруулалтанд оролцохоор битүүмжлэн ирүүлсэн бичиг баримтын хавтасны гадна талын зүүн дээд буланд сонгон шалгаруулалтанд оролцохоор хүсэлт ирүүлж буй хуулийн этгээдийн нэр, хаяг, холбоо барих утас, сонгон шалгаруулалт зарласан талбайн байршил, нэр, сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтийн хуудасны нийт тоо, эх эсхүл хуулбар хувийн аль нь болохыг тодорхой бичсэн байна.
- 3.7. Сонгон шалгаруулалтад оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь сонгон шалгаруулалтын урилгад заасан хугацаанд журмын 3.3.1-д заасан бичиг баримтыг бүрдүүлж сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн даргад биечлэн хүлээлтэн өгнө.
- 3.8. Журмын 3.5 ба 3.6-д заасан шаардлагыг хангасан сонгон шалгаруулалтын саналыг сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нь хүлээн авч Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан ажиллагааг явуулна.

- 3.9. Сонгон шалгаруулалтын санал нь журмын 3.5 ба 3.6-д заасан шаардлагыг хангагүй тохиолдолд сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нь тэмдэглэл үйлдэн буцаасан он, сар, өдөр, цаг, минутыг тэмдэглэсэн тодорхойлолтыг ирүүлсэн хүсэлтийн хамт сонгон шалгаруулалтанд оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчид буцаан өгнө.
- 3.10. Сонгон шалгаруулалтанд оролцох саналыг шуудангаар ирүүлсэн тохиолдолд бүртгэхээс татгалзаж, энэ тухай хариу мэдэгдэнэ.
- 3.11. Сонгон шалгаруулалтын урилгад заасан хугацаа дуусмагц сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтын санал бүртгэх дэвтрийг хааж, ирүүлсэн нийт сонгон шалгаруулалтын саналыг сонгон шалгаруулах комиссын даргад акт үйлдэн хүлээлгэн өгнө.
- 3.12. Сонгон шалгаруулалтын комиссын дарга болон нарийн бичгийн дарга нь оролцогчдоос ирүүлсэн нийт сонгон шалгаруулалтын саналыг тусгай шүүгээнд хийж лацдаж энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олгох

4.1. Сонгон шалгаруулалтын комисс.

- 4.1.1. Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх асуудлыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар шийдвэрлэнэ.
- 4.1.2. Сонгон шалгаруулалтыг тасралтгүй зохион явуулах, ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс 3 (гурав) хүртэл тооны сонгон шалгаруулалтын комиссыг томилж болох бөгөөд комиссын бүрэлдэхүүний 2/3-ийг хагас жил тутамд өөрчилж болно.
- 4.1.3. Сонгон шалгаруулалтын комиссын гишүүн нь геологи, уул уурхай, эрх зүй, эдийн засгийн салбарын мэргэжилтэй, геологийн судалгаа, хайгуул, ашиглалтын төлөвлөгөө, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг үнэлэх мэргэжлийн чадвар, туршлагатай байна.
- 4.1.4. Сонгон шалгаруулалтын комисс нь дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдээс бурдсан нийт 10 (арав) хүний бүрэлдэхүүнтэй байна. Нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтын саналд үнэлгээ хийх эрхгүй бөгөөд тэмдэглэл хөтөлж, тодорхойлолт, дүгнэлтийн төслийг бэлтгэх, сонгон шалгаруулалтын болон сонгон шалгаруулалтын комиссын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.
- 4.1.5. Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнд төрийн захиргааны байгууллагын геологи, уул уурхай, кадастр, хууль эрх зүйн асуудал хариуцсан нэгжийн төлөөллийг заавал оролцуулах бөгөөд нарийн бичгийн даргыг төрийн захиргааны байгууллагаас томилно.
- 4.1.6. Сонгон шалгаруулалтын комиссын саналын эрхтэй гишүүдийн 80 (ная) ба түүнээс дээш хувийн ирцтэйгээр сонгон шалгаруулалт хүчин төгөлдөр болно.
- 4.1.7. Сонгон шалгаруулалтын комисс нь “Төрийн нууцын тухай”, “Байгууллагын нууцын тухай”, “Хувь хүний нууцын тухай” хуульд заасан мэдээллийг задлах, нийтлэх буюу тараахыг хориглоно.

4.2. Сонгон шалгаруулалтын техникийн саналыг нээх.

- 4.2.1. Сонгон шалгаруулах комисс сонгон шалгаруулалтын урилгад заасан газарт, дурдсан хугацаанд техникийн саналыг нээнэ.
- 4.2.2. Сонгон шалгаруулалт зарласан талбайд ирүүлсэн техникийн санал нь журмын 3.3.2, 3.4-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах ажиллагааг тухайн сонгон шалгаруулалтанд оролцогчдын гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нарыг байлцуулан нээлттэй хэлбэрээр явуулна.

- 4.2.3. Сонгон шалгаруулалтанд оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг журмын 4.2.2-т заасан ажиллагаанд оролцох нөхцлийг сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга бүрдүүлнэ.
- 4.2.4. Сонгон шалгаруулалтанд оролцогчоос ирүүлсэн саналын эх хувийг нээж журмын 3.3.2, 3.4-т заасан иж бүрдлийг нь нягтлан шалгаж, дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх ба иж бүрдэл нь бүрэн бол тухайн саналыг хүлээн авна.
- 4.2.5. Хэрэв ирүүлсэн санал нь энэ журмын 3.3.2, 3.4-т заасан шаардлагыг хангаагүй бол тухайн саналыг хүчингүйд тооцон үнэлгээ хийхгүй бөгөөд энэ тухай тэмдэглэл үйлдэж сонгон шалгаруулалтанд оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчид буцаан өгнө.
- 4.2.6. Саналаа ирүүлсэн сонгон шалгаруулалтанд оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь урилгад заасан газар болон цаг хугацаанд хүрэлцэн ирээгүй бол саналыг задлахгүйгээр хүчингүйд тооцон тэмдэглэл үйлдэж, албан бичигт хавсарган журмын 3.6-д заасан холбоо барих утсаар мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш ажлын 3 (гурав) өдөрт багтаан мэдэгдлийг тухайн сонгон шалгаруулалтанд оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хүлээн аваагүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэн журмын 3.3.2.1-т заасан шуудангийн хаягаар буцаан хүргүүлэх бөгөөд ийнхүү баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын 5 (тав) өдөр, орон нутагт ажлын 10 (арав) өдөр, харин цахим шуудангаар явуулсан баримт бичгийг түүнийг илгээнээс хойш ажлын 5 (тав) өдөр өнгөрснөөр хүргүүлсэнд тооцно.

4.3. Сонгон шалгаруулалтын техникийн саналыг үнэлэх.

- 4.3.1. Сонгон шалгаруулалтын техникийн саналыг нээсний дараа нээсэн эх хувийг сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга сонгон шалгаруулалт тус бүрээр нь багцалж, хавтаст хийн лацдаж хадгална. Сонгон шалгаруулалтын комисс нь үнэлгээг хийхдээ шаардлага хангасан сонгон шалгаруулалтын санал тус бүрийн эх хувь дээр үнэлгээ хийнэ. Хэрэв үнэлгээний явцад маргаан гарсан тохиолдолд хуулбар хувийг нээж, эх хувьтай харьцуулах замаар маргааныг шийднэ. Сонгон шалгаруулалтын саналын эх ба хуулбар хувь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтлана.
- 4.3.2. Санал ирүүлсэн сонгон шалгаруулалтанд оролцогчдын баримт бичгүүдийн бүрдлийг нэг бүрчлэн шалгаж баталгаажуулсны дараа сонгон шалгаруулалтанд оролцогчдод техникийн онооны үнэлгээг нийт үнэлгээний 55 (тавин тав) хүртэл хувьд нь өгнө.
- 4.3.3. Сонгон шалгаруулалтанд оролцогчдоос ирүүлсэн санал нь албан ёсны тооцоо, судалгаан дээр сууриссан, хэрэгжих боломжтой, бодитой ажил, үйлчилгээг төлөвлөсөн эсэхийг харгалзан техникийн саналыг үнэлнэ.
- 4.3.4. Сонгон шалгаруулах комиссын гишүүд нь сонгон шалгаруулалтын техникийн саналд доорх шалгуур үзүүлэлтээр үнэлгээг өгнө. Үүнд:
- 4.3.4.1. Геологи, хайгуулын ажлын арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, өмнөх судалгааны материалыг судалсан байдал;
- 4.3.4.2. Байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн төлөвлөлт, ажлын нэр төрөл, түүнд зарцуулах зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа;
- 4.3.4.3. Орон нутгийг хөгжүүлэх, хамтран ажиллах төлөвлөгөө;
- 4.3.4.4. Мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага чадвар;
- 4.3.4.5. Геологи, хайгуулын ажлын болон үйл ажиллагааны туршлага;
- 4.3.4.6. Төсөлд ажиллах, үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал.
- 4.3.5. Техникийн саналын үнэлгээг хийхдээ сонгон шалгаруулалтын комиссын гишүүд нь энэ журмын ... дүгээр хавсралтаар баталсан сонгон шалгаруулалтын үнэлгээний хуудсыг ашиглана.

- 4.3.6. Гишүүдийн өгсөн үнэлгээний үнийн дүнг нэмж, үнэлгээ өгсөн гишүүдийн тоонд хуваан техникийн саналын нийт үнэлгээг гаргах бөгөөд бутархай тоог зуутын орны нарийвчлалтай тодорхойлно.
- 4.3.7. Сонгон шалгаруулалтын комисс нь сонгон шалгаруулалтанд оролцогдоос ирүүлсэн техникийн саналыг ажлын 5 (тав) өдөрт багтаан үнэлж, сонгон шалгаруулах комиссын үнэлгээний хуралдааны тэмдэглэл үйлдэж, дүгнэлт гаргана.
- 4.4. *Сонгон шалгаруулалтын үнийн саналыг нээх.*
- 4.4.1. Техникийн саналыг үнэлж журмын 4.3.6-д заасан дүгнэлт гарснаас хойш ажлын 1 (нэг) өдрийн дотор сонгон шалгаруулалтын комисс нь үнийн саналыг нээх бөгөөд үнийн санал бүрийн дүнг комиссын дарга зарлаж, нарийн бичгийн дарга тэдгээр үнийг самбарт ил харагдахуйц байдлаар бичнэ.
- 4.4.2. Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нь үнийн саналыг нээхдээ сонгон шалгаруулалтанд оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг үнийн санал нээх ажиллагаанд оролцох боломжоор хангана.
- 4.4.3. Сонгон шалгаруулалтад оролцогчид хүсэлт гаргавал комисс тухайн хуулийн этгээдийг бусад оролцогчдын ирүүлсэн үнийн саналтай танилцуулж болно. Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нь үнийн санал нээх ажиллагааны үед тэмдэглэл үйлдэн сонгон шалгаруулалтын комиссын дарга, гишүүдээр баталгаажуулна.
- 4.5. *Сонгон шалгаруулалтын үнийн саналыг үнэлэх.*
- 4.5.1. Сонгон шалгаруулалтанд оролцогчоос ирүүлсэн үнийн санал нь журмын 3.3.3-т заасан шаардлагыг хангаагүй бол 0 (тэг) оноо өгнө.
- 4.5.2. Сонгон шалгаруулаланд оролцогчдоос ирүүлсэн үнийн саналд үнэлгээ өгөхдөө хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчид 45 (дөчин тав) оноог шууд өгнө. Бусад оролцогчдын тухайд ирүүлсэн үнэ тус бүрийг хамгийн өндөр үнийн саналтай харьцуулах хэлбэрээр оноог доор дурдсан томъёог ашиглан тооцоолно.
оролцогчийн үнийн санал
- Оролцогчдын оноо = ----- x 45
хамгийн өндөр үнийн санал
- 4.6. *Сонгон шалгаруулалтын дүнг зарлах*
- 4.6.1. Сонгон шалгаруулалтын комисс нь сонгон шалгаруулалтанд оролцогчдоос ирүүлсэн техникийн санал болон үнийг саналыг журмын 4.3.6, 4.6.2-д заасны дагуу үнэлсэн дүнг нэгтгэн үнэлж, сонгон шалгаруулах комиссын үнэлгээний хуралдааны тэмдэглэл үйлдэж, үр дүнг баталгаажуулсан нэгдсэн дүгнэлт гаргана.
- 4.6.2. Сонгон шалгаруулалтанд оролцсон хоёр болон түүнээс дээш оролцогч нь адил үнэлгээ авсан бол хүсэлтээ хамгийн түрүүнд бүртгүүлсэн оролцогчид тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлтийг гаргана.
- 4.6.3. Сонгон шалгаруулалтын комисс нь нэгдсэн дүгнэлтийг Төрийн захиргааны байгууллагын даргад ажлын 2 (хоёр) өдөрт багтаан хүргүүлнэ.
- 4.6.4. Төрийн захиргааны байгууллагын дарга сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 2 (хоёр) өдөрт багтаан холбогдох тушаалыг гаргана.

- 4.6.5. Сонгон шалгаруулалтын комиссын нэгдсэн дүгнэлт, Төрийн захиргааны байгууллагын даргын тушаалыг үндэслэн Төрийн захиргааны байгууллагын Кадастрын асуудал хариуцсан нэгж нь сонгон шалгаруулалтанд шалгарсан оролцогчид сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай мэдэгдлийг, харин бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг журмын 3.6-д заасан холбоо барих утсаар мэдэгдэнэ.
- 4.6.6. Мэдэгдсэнээс хойш ажлын 3 өдөрт багтаан мэдэгдлийг тухайн оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээн аваагүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэн журмын 3.3.2.1-д заасан шуудангийн хаягаар хүргүүлэх бөгөөд ийнхүү хүргүүлснээс хойш нийслэлд ажлын 5 (тав) өдөр, орон нутагт ажлын 10 (арав) өдөр, харин цахим шуудангаяар явуулсан баримт бичгийг түүнийг илгээнээс хойш ажлын 5 (тав) өдөр өнгөрснөөр мэдэгдлийг хүргүүлсэнд тооцно.
- 4.6.7. Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт зарласан боловч тухайн талбайд хүсэлт ирээгүй бол сонгон шалгаруулалтыг дахин зарлана.
- 4.6.8. Сонгон шалгаруулалтанд шалгараагүй бусад оролцогчийн төлсөн босго үнийг энэхүү журмын 4.6.5-д заасан мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 5 (тав) өдөрт багтаан буцаан олгоно.

4.7. Тусгай зөвшөөрөл олгох.

- 4.7.1. Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогч нь эхний жилийн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан хугацаанд төлсөн бол төрийн захиргааны байгууллага ажлын 3 өдөрт багтаан хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.
- 4.7.2. Хайгуулын тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон талбайн булангийн цэгийн солбицлуудыг тэмдэглэх бөгөөд уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна.
- 4.7.3. Журмын 4.6.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой тухай мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан хугацаанд тусгай зөвшөөрлийг авах боломжгүй тухайгаа мэдэгдсэн, эсхүл сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, эхний жилийн төлбөрийг төлөөгүй бол төрийн захиргааны байгууллага нь журмын 4.6.5-д заасан мэдэгдлийг хүчингүй болгож, хүсэлт гаргасан хуулийн этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэх бөгөөд тухайн талбайн сонгон шалгаруулалтанд удаах өндөр оноо авсан оролцогчийг шалгарсанд тооцно.
- 4.7.4. Хэрэв тухайн талбайн сонгон шалгаруулалтанд оролцож шалгарсан оролцогч нь сонгон шалгаруулалтын үнийн саналд тусгасан мөнгөн дүнг энэхүү журмын 4.6.5-д заасны дагуу төлөөгүй бол тус оролцогчийн босго үнийг улсын төсөөвт оруулж, буцаан олгохгүй.
- 4.7.5. Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.
- 4.7.6. Сонгон шалгаруулалтанд оролцогчдоос ирүүлсэн техникийн болон үнийн саналууд, тэдгээрийг хэрхэн үнэлсэн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.
- 4.7.7. Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан тухай тайланг бичиж, санал ирүүлсэн материалын бүртгэлийг талбай тус бүрээр нь хөтөлж багцлан сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 10 (арав) өдөрт багтаан Төрийн захиргааны байгууллагын Кадастрын асуудал хариуцсан нэгжийн архивт хүлээлгэн өгнө.

ТАВДУГААР ЗҮЙЛ. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын комисс болон оролцогчийн эрх, үүрэг

5.1. Сонгон шалгаруулалтын комиссын эрх, үүрэг.

- 5.1.1. Сонгон шалгаруулалтыг урилгад заасан газарт, дурдсан хугацаанд нь эхлүүлэх;
- 5.1.2. Сонгон шалгаруулалт явуулах тухай холбогдох тушаал, шийдвэрийг танилцуулах, оролцогдоос сонирхсон асуудлаар тавьсан асуултанд тайлбар өгөх;
- 5.1.3. Сонгон шалгаруулалт зарласан талбайд 1 (нэг) болон түүнээс дээш санал ирсэн бол сонгон шалгаруулалтыг хүчинтэйд тооцох;
- 5.1.4. Сонгон шалгаруулалт зарласан талбайд ирүүлсэн бүх сонгон шалгаруулалтын хүсэлт болон түүнд хавсаргасан материалыг энэ журамд заасан шаардлагыг хангаагүй бол сонгон шалгаруулалтыг хүчингүй болгож, дахин сонгон шалгаруулалт явуулах тухай дүгнэлт гаргах;
- 5.1.5. Сонгон шалгаруулалтын үйл явцыг баримтжуулж, тухай бүр тэмдэглэл үйлдэх; Сонгон шалгаруулалтын саналд үнэлгээг үнэн зөв өгөх.

5.2. Сонгон шалгаруулалтанд оролцогчийн эрх, үүрэг.

- 5.2.1. Сонгон шалгаруулалтын журамтай танилцах;
- 5.2.2. Сонгон шалгаруулалтын урилгаар зарласан хэд хэдэн талбайн сонгон шалгаруулалтанд оролцох;
- 5.2.3. Сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлттэй танилцах;
- 5.2.4. Сонгон шалгаруулалтын саналыг үнэн зөв бүрдүүлэх;
- 5.2.5. Сонгон шалгаруулалтын комиссын шийдвэрт гомдол гаргах.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Бусад зүйл

6.1. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага.

- 6.1.1. Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэд хавсаргасан баримт бичиг нь энэхүү журмын 3.3.1-д заасан шаардлагыг хангаагүй, баримтаар нотлогдоогүй эсхүл илт хуурамч бол сонгон шалгаруулалтын комисс үнэлгээ хийхээс татгалзаж, энэ тухай хурлын тэмдэглэлд тусгана.
- 6.1.2. Сонгон шалгаруулалтын саналыг үнэлэх явцад комиссын гишүүн нь энэхүү журамд заасныг зөрчиж, эрх мэдлээ урвуулан ашигласан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 6.1.3. Тухайн сонгон шалгаруулалтанд оролцогч нь хэт өндөр үнийн саналыг /бусад оролцогчдын үнийн саналаас 50-иас дээш хувиар их/ санаатайгаар ирүүлээд түүнийгээ төлөхөөс татгалзвал тухайн оролцогчийг энэ журмаар зохицуулагдаж байгаа сонгон шалгаруулалтанд дахин оролцуулахгүй.

6.2. Маргааныг хянан шийдвэрлэх.

- 6.2.1. Сонгон шалгаруулалтанд оролцогч нь сонгон шалгаруулалтын явцад өөрийнх нь эрх ашиг хөндөгдсөн гэж үзвэл Төрийн захиргааны төв байгууллагад гомдол гаргаж болно.
- 6.2.2. Сонгон шалгаруулалтанд оролцогч нь Төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

6.3. Бусад асуудал.

- 6.3.1. Энэхүү журамд заасан сонгон шалгаруулалтын саналыг бүртгэх дэвтрийн маягтыг Төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батална.
- 6.3.2. Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогчийн техникийн саналд тусгасан хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх, түүнийг хайгуулын ажлын жилийн тайланд тайлагнасан эсэхэд Төрийн захиргааны байгууллага хяналт тавьж Ашигт малтмалын тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллана.

-оОо-

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ...дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МАЯГТ 1

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

..... оны ... дугаар сарын -ны өдөр

(аж ахуйн нэгжийн нэр)

(талбайн нэр)

(аймаг, нийслэл)

(сум, дүүрэг)

№		Шалгуур үзүүлэлт	Жишиг оноо	Онооны хязгаар	Нийт оноо хүртэл
1		Төслийн баримт бичгийн үнэлгээ			25
1.1	Геологи хайгуулын ажлын талаар			0-15	
	Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн судалсан		11-15		
	Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй		6-10		
	Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн судалсан		1-5		
	Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй		0		
1.2	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөлт, ажлын нэр төрөл, түүнд зарцуулах зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацааг харгалзан			0-6	
	Хангалттай		6		
	Хангалтгүй		0		
	Орон нутгийг хөгжүүлэх, хамтран ажиллах төлөвлөгөө			0-4	
	Энэхүү журмын 3.3.2.8 дугаар заалтыг хангасан		4		
	Энэхүү журмын 3.3.2.8 дугаар заалтыг хангаагүй		0		
2		Мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага чадвар			11
2.1	Төсөлд ажиллах Монгол ажилтнуудын эзлэх хувь 100% бол		3	1-3	
	Төсөлд ажиллах Монгол ажилтнуудын эзлэх хувь 90%-аас дээш бол		2		
	Төсөлд ажиллах Монгол ажилтнуудын эзлэх хувь 90% буюу түүнээс доош бол		1		
2.2	Төсөлд МУ-ын зөвлөх болон мэргэшсэн геологич аль аль нь ажиллах бол		3	0-3	
	Төсөлд МУ-ын зөвлөх геологич ажиллах бол		2		
	Төсөлд МУ-ын мэргэшсэн геологич ажиллах бол		1		

	<i>Төсөлд МУ-ын зөвлөх болон мэргэшсэн геологич аль аль нь байхгүй бол</i>	0		
2.3	<i>Төсөлд оролцох ИТАжилтан болон Геологичид нь 100 хувь үндсэн ажилтантай бол</i>	5	1-5	
	<i>Төсөлд оролцох ИТАжилтан болон Геологичид нь үндсэн болон гэрээт ажилчдаас бүрдэх бол</i>	3-4		
	<i>Төсөлд оролцох ИТАжилтан болон Геологичид нь 100 хувь гэрээт ажилтантай бол</i>	2		
	<i>Төсөлд ямар нэг тодорхой ИТАжилтан болон геологич тусгагдаагүй бол</i>	1		
3	Геологи, хайгуулын ажлын болон үйл ажиллагааны туршлага			10
3.1	Монголын геологи, хайгуул, уул уурхайн салбарт 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол	4	1-4	
	Монголын геологи, хайгуул, уул уурхайн салбарт 5-10-н жил үйл ажиллагаа явуулсан бол	2-3		
	Монголын геологи, хайгуул, уул уурхайн салбарт 5 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан бол	1		
3.2	Бусад салбарт 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол	2	1-2	
	Бусад салбарт 5 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан бол	1		
3.3	Геологи хайгуулын төсөл, үйл ажиллагааг бие даан явуулсан, хангалттай баялаг туршлагатай	3-4	1-4	
	Геологи хайгуулын төсөл, үйл ажиллагаа явуулсан болон туслан гүйцэтгэгчээр оролцож байсан	1-2		
4	Төсөлд ажиллах техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал			9
4.1	Төсөл хэрэгжүүлэгч ААН геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн эзэмшлийн өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан бол	9	1-9	
	Төсөл хэрэгжүүлэгч ААН геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийн 50-аас дээшгүй хувийг түрээсэлдэг бол	5-8		
	Төсөл хэрэгжүүлэгч ААН геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийг бүгдийг түрээсэлдэг бол	1-4		
НИЙТ ОНОО				55

Үнэлгээг баталгаажуулсан:

Сонгон шалгаруулалтын комиссын дарга /......./

Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга /......./

Сонгон шалгаруулалтын комиссын гишүүд //

//

//

//

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
...дугаар тушаалын 3 дугаар хавсралт

МАЯГТ 2

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙН НЭГТГЭЛ**

..... оны . . . дугаар сарын . . . -ны өдөр

(аж ахуйн нэгжийн нэр)

(талбайн нэр)

(аймаг, нийслэл)

(сум дүүрэг)

№	Оролцогчийн нэр	Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	Комиссын гишүүдийн үнэлгээний оноо							Дундаж оноо	Тайлбар
			гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1		ТЕХНИКИЙН ҮНЭЛГЭЭ									
		Төслийн баримт бичгийн үнэлгээ									
		Мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага, чадвар									
		Геологи, хайгуулын ажлын болон үйл ажиллагааны туршлага									
		Төсөлд ажиллах техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал									
		Нийт гишүүдийн техникийн онооны арифметик дундаж									
		САНХҮҮГИЙН ҮНЭЛГЭЭ									
		Үнийн санал									
		Нийт санхүүгийн онооны арифметик дундаж									
		БҮГД									

Үнэлгээг баталгаажуулсан:

Сонгон шалгаруулалтын комиссын дарга /......./

Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга /......./

Сонгон шалгаруулалтын комиссын гишүүд /......./

/......./

/......./

/......./

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2017 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
...дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

МАЯГТ 3

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН
ҮНЭЛГЭЭНИЙ НИЙТ НЭГТГЭЛ
(Бүх талбайгаар)**

.... оны ... дугаар сарын ... -ны өдөр
.....
(.....)

№	Талбайн нэр	Оролцогчийн нэр	байр	Комиссын гишүүдийн үнэлгээний оноо								Дундаж оноо	Тайлбар
				гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		

Үнэлгээг баталгаажуулсан:

Сонгон шалгаруулалтын комиссын дарга /......./

Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга /......./

Сонгон шалгаруулалтын комиссын гишүүд /......./

/......./

/......./

/......./